Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн
хуралдааны 2026 оны 10 дугаар сарын 02-ны
өдрийн 72 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Өгөгдлийн тухай (анхдагч) хуулийн төсөл болон үүнтэй уялдуулан боловсруулж ирүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх санал

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номингоос Өгөгдлийн тухай (анхдагч) хуулийн төсөл, уг хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан дагалдах хуулиудын төсөлд санал авахаар Улсын дээд шүүхэд ирүүлснийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-т заасны дагуу Нийт шүүгчийн 2026 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар хэлэлцээд дараах саналыг хүргүүлж байна.

Нэг. Хуулийн төслийн үйлчлэх хүрээ, зохицуулах харилцаанаас хуульд тухайлан зааснаас бусад шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах аливаа өгөгдлийн эргэлттэй холбоотой харилцааг хасах талаар:

Төслөөр Өгөгдлийн тухай (анхдагч) хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлдэж байгаа аливаа өгөгдлийн эргэлттэй холбоотой харилцааг зохицуулахаар заасан бөгөөд хуулийн үйлчлэх хүрээнд "эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хамаарахгүй" гэж төслийн 3 дугаар зүйлийн 3.3.2-т зааж, иргэний болон захиргааны түүнчлэн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дурдаагүй орхисон нь Өгөгдлийн тухай (анхдагч) хуулийн үйлчлэх хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ хамаарахаар агуулгатай байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэх асуудлыг энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ", 12.2.1-д "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг энэ хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу сонирхогч этгээд танилцах боломжийг бүрдүүлэх", 12.4-т "Сонирхогч этгээд энэ хуулийн 12.2.1-д заасан мэдээлэлтэй танилцах журмыг Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн батална" гэж тус тус заасан, аливаа хэрэг маргааныг шүүхэд хянан шийдвэрлэхэд хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан хувийн мэдээлэл, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллүүд хэлэлцэгддэг, эдгээр нь өгөгдлийн нээлттэй санд байршиж, эргэлтэнд орох боломжгүй юм.

Монгол Улсын шүүхийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус заасан үндэслэл, журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нээлттэй мэдээллийг шүүхээс олон нийтэд хүргэдэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цугларсан ямар мэдээллийг өгөгдлийн нээлттэй санд нийлүүлэх, ямар мэдээлэл нь хаалттай байхыг хуулиар тусгайлан зохицуулдаг тул иргэний, захиргааны, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь Өгөгдлийн тухай хуулийн үйлчлэлд хамааруулах боломжгүй, аливаа хэрэг маргааныг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ уг хуулийн үйлчлэлээс хасагдах шаардлагатай гэж үзэж байна.

Уг санал нь шүүхийн дата мэдээллийг бүхэлд нь нууцлах агуулгагүй бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн үйл ажиллагаанд холбогдох статистикийн болон бусад нээлттэй мэдээллийг хуульд заасан журмын дагуу улирал тутамд нэгтгэн гаргаж, олон нийтэд мэдээлдэг.

Тухайлбал, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 болон 75 дугаар зүйлүүдэд "... Шүүхийн ерөнхий зөвлөл нь хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, ажиллагаанд байгаа хэргийн насжилт, тодорхой хэргийн хөдөлгөөний талаар хяналт-шинжилгээ хийх, хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тогтоосон журмын дагуу хуваарилсан, томилсон эсэхэд хяналт тавих, улирал бүр нийтэд мэдээлэх", "... бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол мэдээлэх, шүүхийн шийдвэр, тогтоолыг эмхэтгэн хэвлэх болон цахим хуудаст тогтмол байршуулах" үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т зааснаар шүүхийн статистикийн үзүүлэлтийг[1] мөн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл Үндэсний статистикийн хороонд тухай бүр хүргүүлдэг байна.

Шүүхийн үйл ажиллагааны талаарх эдгээр нээлттэй мэдээллүүд, Үндэсний статистикийн хороонд жил бүр хүргүүлдэг тоон мэдээ нь улсын хэмжээний өгөгдлийн санд нэгтгэгдэж, судалгааны болон бусад эргэлтэд ордог.

Нөгөөтээгүүр Өгөгдлийн тухай хуулийн төслийн тандан судалгааны хүрээнд төслийг боловсруулахдаа Европын холбоо (цаашид "ЕХ" гэх)-ны Өгөгдөл хамгаалах ерөнхий журам (англ. *General Data Protection Regulation – GDPR*), бусад ЕХ-ны улсуудын зохицуулалт, загварыг харьцуулан судалснаа дурдсан[2], судалгаанд хамааруулсан ЕХ-ны улсуудын хэмжээнд "Өгөгдөл хамгаалах ерөнхий журам"-аар

---

[1] 4/шүүхийн статистикийн үзүүлэлт:
а/ эрүүгийн хэргийн тоо, төрөл;
б/ шүүхээр шийтгүүлэгчдийн тоо, нас, хүйсийн ялгаа;
в/ гэмт хэргийн улмаас учирсан хохирол;
г/ дампуурсан аж ахуйн нэгж;
д/ захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт.

[2] Өгөгдлийн тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, 4 дэх тал;
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, *Өгөгдлийн тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа* (Улаанбаатар: 2026 он), 42 дахь тал.

шүүх эрх мэдлийн байгууллагын өгөгдлийг тусгайлан авч үзсэнийг анхаарах шаардлагатай.

Тодруулбал, тус журмын 55 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Хяналт тавих эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд шүүх шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд өгөгдөл боловсруулах үйл ажиллагаа хамаарахгүй"[3] гээд мөн зүйлийн удиртгал буюу тайлбар болох "Шүүхийн бие даасан байдлыг хангах" хэмээх 20 дугаар зүйл (англ. *Recital 20*)-д дараах байдлаар заажээ. Үүнд:

> "... (2) Шүүхийн шийдвэр гаргах зэрэг шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхэд шүүхийн бие даасан байдлын баталгааг хангах үүднээс хяналт тавих эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд шүүх шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд хувийн мэдээлэл боловсруулах ажиллагаа хамаарахгүй.
>
> (3) Ийм өгөгдөл боловсруулах ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг Гишүүн улсын шүүхийн тогтолцооны тусгайлсан байгууллагад хариуцуулж болох бөгөөд тухайн байгууллага нь ялангуяа энэхүү журмын хэрэгжилтийг хангуулах, журмаар хүлээсэн үүргийн талаар шүүгчдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, мөн ийм өгөгдөл боловсруулах ажиллагаатай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ"[4] гэсэн байна.

Өөрөөр хэлбэл, хуульд тухайлан нээлттэй байршуулахаар заасан, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх тоон мэдээллээс бусад тохиолдолд шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой өгөгдлүүдийг нээлттэй өгөгдлийн санд шууд нэгтгэн эргэлтэнд оруулахыг олон улсын хэмжээнд зөвшөөрдөггүй байна.

Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн адил зөрчил, иргэн, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг Өгөгдлийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй байхаар хуулийн төсөлд заах, ингэхдээ шүүн таслах харилцаа нь "батлан хамгаалах, гүйцэтгэх ажил"-аас тусдаа тул тусад нь төслийн 3 дугаар зүйлийн "*3.3.4.эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах өгөгдлийн эргэлттэй холбоотой харилцаа*" гэж, түүнчлэн 3 дугаар зүйлийн "*3.4.Эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах өгөгдлийн эргэлттэй холбоотой харилцааг Монгол Улсын шүүхийн тухай хуулиар зохицуулна*" гэж тус тус нэмэх нь зүйтэй.

Энэ хүрээнд Монгол Улсын шүүхийн тухай хуульд холбогдох өөрчлөлтийг Өгөгдлийн тухай хуулийн төслийг дагалдуулан оруулах саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Харин Өгөгдлийн тухай хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан "Үндэсний өгөгдлийн зөвлөлийн бүрэлдэхүүн"-д шүүх эрх мэдлийн байгууллагын төлөөлөл, тухайлбал Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөллийг оруулах замаар уг харилцаанд холбогдох байгууллагуудын хоорондын уялдааг хангаж, хамтран ажиллах боломжийг судлан үзэхийг санал болгов.

---

[3] GDPR 55(3) "Supervisory authorities shall not be competent to supervise processing operations of courts acting in their judicial capacity", https://gdpr-info.eu/art-55-gdpr/.

[4] GDPR Recital 20, "*Respecting the Independence of the Judiciary*", https://gdpr-info.eu/recitals/no-20/.

Хоёр. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.14 дэх хэсгийг Захиргааны ерөнхий хуультай уялдуулах талаар

Өгөгдлийн тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.12, 11.13-т зааснаар төрийн өгөгдөл хариуцагч этгээд нь тодорхой тохиолдолд холбогдох өгөгдлийг нээлттэй өгөгдөл болгон нийтлэхийг хориглосон байх бөгөөд энэ хүрээнд гаргасан шийдвэр нь захиргааны байгууллагын шийдвэр болох юм.

Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.3 дахь хэсэгт "Гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүлээн авч, **хуульд өөрөөр заагаагүй** бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө" гэж заасны дагуу төслийн 11 дүгээр зүйлийн 11.14 дэх хэсгийг "*11.14.Энэ хуулийн 11.13-т заасан үндэслэлээр өгөгдөл хариуцагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 93, 94 дүгээр зүйлд заасан журмын дагуу өгөгдөл хариуцагчид гомдол гаргана*" гэж өөрчлөн найруулах, мөн зүйлд "*11.15.Энэ хуулийн 11.14-т зааснаар гаргасан гомдлыг өгөгдөл хариуцагч Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүлээн авч, ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэх бөгөөд гомдлыг хянах хугацаанд тухайн өгөгдөлд хандах хандалт, нийтлэлтийг түр зогсооно*" гэж нэмснээр уг хууль болон Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтууд хоорондоо уялдахаар байна.

Гурав. Хуулийн төслийн мэдээллийн технологийн шинжтэй зарим зохицуулалтыг боловсронгуй болгох талаар

3.1. Өгөгдлийн тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан "өгөгдөл үнэн зөв" байх зарчмын хүрээнд эх сурвалжийг тодорхой заагаагүй, эх үүсвэр тодорхойгүй өгөгдлийг өгөгдлийн санд оруулахгүй байх, түүнчлэн өгөгдлийн сангаас өгөгдлийн эх сурвалжийг тодорхой харж болдог байхаар зохицуулах нь зүйтэй. Иймд хуулийн төслийн 8 дугаар зүйлийн "*8.3.4.өгөгдлийн эх сурвалжийг тодорхой зааж, харуулдаг байх*" гэсэн зохицуулалт нэмэх саналтай байна.

3.2. Өгөгдлийн тухай хуулийн төслийн үйлчлэх хүрээнээс эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах өгөгдлийн эргэлттэй холбоотой харилцааг хассанаар хуулийн төслийн бусад зохицуулалт хамааралгүй болох хэдий ч төслийн 12 дугаар зүйлийн 12.5-д заасан өгөгдөл устгах тохиолдол үүссэн боловч тухайн өгөгдөл шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтаар авагдах, шинжлэн судлах шаардлагатай гуравдагч этгээдийн эзэмшиж байгаа өгөгдөл байх боломжтой юм.

Түүнчлэн, ЕХ-ны Өгөгдөл хамгаалах ерөнхий журмын "устгуулах эрх (мартагдах эрх)" хэмээх 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт өгөгдөл устгах тохиолдол хамаарахгүй байх нөхцөлийг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

"3.Дараах зорилгоор өгөгдөл боловсруулах зайлшгүй шаардлагатай бол [энэ зүйлийн] 1 болон 2 дахь хэсэг үйлчлэхгүй:

(б) Мэдээлэл хариуцагчийн дагаж мөрдөх Холбооны эсхүл Гишүүн улсын хуулиар хүлээсэн хууль ёсны үүргийг биелүүлэх буюу нийтийн ашиг сонирхолд нийцсэн чиг үүргийг гүйцэтгэх, эсхүл мэдээлэл хариуцагчид олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд;

(д) Нэхэмжлэл гаргах, хэрэгжүүлэх, эсхүл хариу тайлбар гаргахад"[5] гэж зохицуулсныг анхаарах нь зүйтэй.

Иймд төслийн 12 дугаар зүйлийн "*12.6.Энэ хуулийн 12.5-д заасан тохиолдол үүссэн боловч тухайн өгөгдөл нь эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох бариmтаар авагдсан бол тухайн ажиллагаа дуусах хүртэл өгөгдлийг устгахыг хориглоно*" гэсэн агуулгатай зохицуулалт нэмэх саналтай байна.

Дөрөв. Хуулийн төслийн дагалдах хуульд нэмэлт оруулах төслийн талаар

4.1. Өгөгдлийн тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.12-т нээлттэй өгөгдөл нийтлэх төрийн өгөгдөл хариуцагчийн үүрэг, мөн 11.13-т нээлттэй өгөгдөл болгон нийтлэхийг хориглосон тохиолдол, 11.14- тийнхүү нийтэлсэн тохиолдолд гомдол гаргах, шийдвэрлэх, улмаар төрийн өгөгдөл хариуцагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл төслийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу гомдол гаргаж болохоор тус тус хуульчилжээ.

Гэтэл мөн тийнхүү нээлттэй нийтлэхийг хориглосон өгөгдлийг нийтэлсэн тохиолдолд тус үйлдлийг зөрчил болгон зүйлчилж, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулахаар төсөл боловсруулсан байх бөгөөд өгөгдөл хариуцагчийг 20,000 нэгж буюу 20,000,000 (хорин сая) төгрөгөөр торгохоор байгаа нь захиргааны байгууллагын хувьд гомдол шийдвэрлэх механизмын давхардал үүсгэж болзошгүй байна.

Иймд Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах төслөөс "2.Өгөгдлийн тухай хуулийн 11.13-т заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон нийтлэхийг хориглосон өгөгдлийг нийтэлсэн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэснийг хасах саналтай байна.

[5] GDPR 17(3) "Right to erasure ('right to be forgotten')", https://gdpr-info.eu/art-17-gdpr/.

Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн
хуралдааны 2026 оны 10 дугаар сарын 02-ны
өдрийн 72 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Өгөгдлийн тухай (анхдагч) хуулийн төсөлтэй уялдуулан
Монгол Улсын шүүхийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах санал

Нэг. Хэрэгцээ, шаардлагын үндэслэл

Өгөгдлийн тухай анхдагч хуулийн үйлчлэх хүрээ, зохицуулах харилцаанаас хуульд тухайлан зааснаас бусад шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах аливаа өгөгдлийн эргэлттэй холбоотой харилцааг хасах талаар гаргасан саналтай уялдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлага үүсэхийг дараах байдлаар тодорхойлов.

Монгол Улсын шүүхийн цахим шилжилтийн хүрээнд бүх шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх болон шүүхийн захиргааны үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлж, байнгын ашиглалтад шилжүүлэх үе шат руу шилжиж байна. Үүнтэй уялдуулан цахим системийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал, технологийн дэд бүтэц, мэргэжлийн хүний нөөц, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага урган гарч байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд шүүхийн цахим талбар, төрөлжсөн цахим мэдээллийн сантай холбоотой зохицуулалт хуульчилсан. Түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-д мэдээллийн технологийн дундын төв байгуулах, шүүхийн мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэх, тогтвортой санхүүжилтийг хангах зорилт дэвшүүлсэн болно.

Иймд дээрх бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, шүүхийн цахимжилтын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяанд мэргэжлийн төв ажиллуулах эрх зүйн үндэс бүрдүүлэх шаардлагатай юм.

Шүүх дэх цахим шилжилтийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн захиргаа, иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт хөрвүүлэх бодит үе шат руу ойртоход программ хангамж хөгжүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахаас гадна тэдгээрийг урт хугацаанд тогтвортой ажиллуулах мэргэшсэн хүний нөөц, өгөгдлийн дэд бүтэц, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх нэн чухал шаардлага тулгарч байна. Энэ нь ойрын хугацаанд шүүхийн цахим системийг бодит хэрэглээнд нэвтрүүлэх, улмаар 2030 он гэхэд шүүх өөрсдийн мэргэшсэн хүний нөөц, технологийн дэд бүтэц, системийн ашиглалт, хөгжүүлэлтийг хариуцах чадавх бүрдүүлэх хэрэгцээтэй шууд холбоотой юм.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд шүүхийн цахим талбар, төрөлжсөн цахим мэдээллийн сантай холбоотой асуудлыг хуульчилсан. Гэсэн хэдий ч шүүхийн цахимжилтыг тогтвортой хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагын зохион байгуулалт, бие даасан өгөгдлийн дэд бүтэц, хүний нөөц, төсөв, санхүүжилтийн асуудлыг цогцоор нь зохицуулах шаардлага хэвээр байна.

Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор батлсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-ын 6.2.1-д программ хангамж, систем хөгжүүлэлт, кибер аюулгүй байдал хариуцсан мэдээллийн технологийн дундын төв байгуулах; 6.2.2-т мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг сайжруулах, хиймэл оюун ухаан, блокчейн зэрэг шийдэл нэвтрүүлэх; 6.2.3-т шүүхийн дата төвийн хүчин чадлыг сайжруулах зорилт, мөн бодлогын 7 дугаар зорилгын хүрээнд тогтвортой, урьдчилан тооцоолсон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхээр тус тус заасан. Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 332 дугаар тогтоолоор “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого”-ыг батлсан билээ. Энэхүү бодлого шүүхийн цахим шилжилтийг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хэрэгжүүлэхэд чиглэсэн бөгөөд дээр дурдсан шаардлагатай уялдах юм.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяанд Цахимжилтын төв байгуулах, түүний эрх зүйн байдал, чиг үүрэг, зохион байгуулалт, санхүүжилтийн үндсийг бүрдүүлж, дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилтуудыг бодитоор хэрэгжүүлэх нь чухал болж байна.

Хоёр. Өнөөгийн бодит нөхцөл байдал

2.1. Системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн үе шат

Монгол Улсын шүүхийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа “Цахим шүүх 2.0” цөм системийн төслийн хүрээнд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системийг 2025 оны 7 дугаар сараас туршин нэвтрүүлсэн тэдийгүй мөн оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс зөрчлийн хэргийн болон таслан сэргийлэх арга хэмжээний бүртгэлийн системийг ашиглаж эхэлсэн билээ. Улмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс туршин нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Түүнчлэн 2026 оны 11 дүгээр сарын 01-ний дотор зөрчлийн хэргийг бүрэн цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цагдаа, прокурорын байгууллагын системтэй холбох интеграцийн ажил идэвхтэй үргэлжилж байна. Харин иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны системийг 2026 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс бодит хэрэглээнд шилжүүлэх боломжийг судалж байгаа бөгөөд энэ талаар эцсийн шийдвэр гараагүй байна.

Гэсэн хэдий ч иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем бодит хэрэглээнд шилжихтэй холбогдуулан хэргийн оролцогчид шүүхтэй цахимаар харилцах, цахимаар нэхэмжлэл, нотлох баримтаа гаргах Хэргийн оролцогчдын систем (цаашид “ХОС” гэх)-ийг нэвтрүүлэх хэрэгцээ нэмэгдэх юм. Мөн ХОС болон зөрчлийн хэргийн системийн хэрэглээ өргөжихөд системийн ачаалал, өгөгдөл хадгалах хэмжээ, техникийн дэмжлэг, аюулгүй байдлын шаардлага дагалдан өснө.

2.2. Хүний нөөц, ур чадвар

Шүүхийн байгууллагад мэдээллийн технологийн мэргэжилтний тоо хүрэлцээ муутай бөгөөд одоогийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг шинэ цөм системийн архитектур, өгөгдлийн сан, сүлжээ, сервер, кибер аюулгүй байдал, системийн

ашиглалт, хөгжүүлэлтийн шаардлагад нийцүүлэн дээшлүүлэх хэрэгцээ байна. Өнөөгийн байдлаар цахим системийн хөгжүүлэлтэд гүйцэтгэгч компанийн мэргэжлийн баг голлох үүрэгтэй оролцож байгаа тул технологийн мэдлэг, туршлагыг шүүхийн мэргэжлийн багт үе шаттай шилжүүлэх, системийн цаашдын хөгжүүлэлт, ашиглалт, аюулгүй байдлыг хариуцах хүний нөөц бэлтгэх шаардлага урган гарах нь зайлшгүй.

Түүнчлэн мэдээллийн технологийн нарийн мэргэжлийн ажилтан сонгон шалгаруулах, сургаж мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах нөхцөл бүрдүүлэх нь шүүхийн цахим системийн урт хугацааны найдвартай ажиллагааг хангах үндсэн нөхцөлийн нэг болно.

2.3. Дэд бүтэц, өгөгдлийн хадгалалт, аюулгүй байдал

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем, ХОС, дотоод үйл ажиллагааны ERP зэрэг системүүдийг тасралтгүй, найдвартай ажиллуулахын тулд сервер, сүлжээ, өгөгдөл хадгалалт, нөөц, сэргээн босголт, кибер аюулгүй байдлын техник, технологийн дэд бүтэц, хүний нөөцийн хүчин чадлыг цогцоор нь бүрдүүлэх шаардлагатай. Улмаар цаашид шүүхийн бие даасан дата төвийн дэд бүтэц хөгжүүлэх, хүчин чадлыг бэхжүүлэх хэрэгцээ буй бөгөөд цахим системүүдийн хэрэглээ өргөжихийн хэрээр өгөгдөл хадгалах нөөц, системийн найдвартай ажиллагаанд тавигдах шаардлага нэмэгдэнэ.

Тодруулбал, тодорхой хэмжээний багтаамжтай хадгалах төхөөрөмж худалдан авах нь дангаараа дата төвийн цогц шийдэл, шүүхийн цахим системүүдийн өсөн нэмэгдэх хэрэгцээг бүрэн хангах баталгаа болохгүй юм. Иймд одоогийн дэд бүтцийн ашиглалт, хадгалах багтаамж, нөөцлөлт, өргөтгөх боломжийг үнэлж, цаашдын хөгжлийн хэрэгцээг тодорхойлох шаардлагатай.

2.4. Байгууллагын бүтэц, чиг үүрэг, уялдаа

Мэдээллийн технологийн чиг үүрэг, хариуцлагын хуваарилалт, нэгж хоорондын ажлын уялдаа, төлөвлөлт, хэрэгжилтэд тавих хяналтыг илүү тодорхой болгох шаардлагатай тул эдгээр чиг үүргийг нэгдсэн зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах, шүүхийн цахимжилтыг системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтээс эхлэн байнгын ашиглалт, засвар үйлчилгээ, цаашдын шинэчлэл хүртэл нэгдсэн байдлаар хариуцах тусгайлсан бүтэц бий болгоогүй нь системийн цаашдын тогтвортой ажиллагаанд эрсдэл үүсгэнэ.

Түүнчлэн анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хэрэгцээ, шаардлагыг нэгтгэн тодорхойлох, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны оролцоог хангах, цахим системийн хөгжүүлэлт, өөрчлөлтийг нэгдсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх зохион байгуулалтыг бэхжүүлэх шаардлагатай болно. Энэ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бодлого, удирдлага, хяналтын чиг үүргийг цахимжилтын өдөр тутмын хэрэгжилтийг хариуцах мэргэжлийн бүтэцтэй уялдуулах эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэх хэрэгцээ үүсэж байгаа юм.

2.5. Төсөв, санхүүжилт

Шүүхийн цахимжилт нь цахим системийг шинээр хөгжүүлж, нэвтрүүлэхээс гадна түүний байнгын ашиглалт, засвар үйлчилгээ, шинэчлэл, мэдээллийн болон

кибер аюулгүй байдал, өгөгдлийн дэд бүтэц, мэргэжлийн хүний нөөцийг тасралтгүй санхүүжүүлэх шаардлагатай урт хугацааны үйл ажиллагаа мөн.

Гэвч шүүхийн цахимжилтад шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал жил бүрийн төсөв боловсруулах, хэлэлцэх явцад буурах, хасагдах нөхцөл байдал давтагдаж байгаа нь төлөвлөсөн ажлыг хугацаанд нь хэрэгжүүлэх, системийн хөгжүүлэлт, технологийн шинэчлэлийг тасралтгүй үргэлжлүүлэхэд хүндрэл учруулж байна. Тухайлбал, 2027 оны улсын төсвийн төсөлд шүүхийн цахимжилтын хөрөнгө оруулалтын зардлыг бүхэлд нь хассанаар санхүүжилтийн тогтвортой байдал хангагдахгүй байх эрсдэлтэй.

Мөн цахим системийн хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн худалдан авалт, нийлүүлэлт, суурилуулалт, ашиглалтад оруулах ажиллагаа нь хэд хэдэн төсвийн жилийг дамнан хэрэгжих онцлогтой бөгөөд тоног төхөөрөмжийн үнэ, технологийн шаардлага, системийн хүчин чадал, мэдээллийн аюулгүй байдлын хэрэгцээ цаг хугацааны явцад өөрчлөгдөх боломжтой тул хөрөнгө оруулалтыг үе шаттай, харилцан уялдаатай төлөвлөх шаардлагатай. Санхүүжилт тасалдах нь нэгэнт оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, гүйцэтгэл удаашрах, цахим системийн найдвартай ажиллагаанд эрсдэл үүсэхэд хүргэж болзошгүй.

Иймд шүүхийн цахимжилтын урсгал зардал, хөрөнгө оруулалт, системийн хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдал, технологийн дэд бүтцийн шинэчлэлийг шүүхийн төсвийн бүрэлдэхүүнд тогтвортой төлөвлөж, санхүүжүүлэх эрх зүйн болон зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай юм.

Шүүхийн цахим шилжилтийн бодлого, программ хангамжийн хөгжүүлэлт, техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитоор хэрэгжүүлэхэд эдгээрийг тогтвортой ажиллуулах институцийн, хүний нөөцийн, өгөгдлийн дэд бүтцийн, санхүүгийн тус тус эрх зүйн үндсийг цогцоор нь бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем, ХОС-ийг ашиглалтад оруулахад ойртож буй өнөөгийн нөхцөл, 2030 онд гүйцэтгэгчийн гэрээт ажил дуусмагц дотоодын мэргэжлийн чадавх бүрдүүлсэн байх хэрэгцээ, улсын төсвийн 14.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бэхжүүлэх шаардлага зэрэг нь Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд ойрын хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болж байна.

Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд ажиллуулах Цахимжилтын төвийн эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлж, түүний чиг үүрэг, удирдлага, мэргэжлийн хүний нөөц, өгөгдлийн дэд бүтэц, төсвийн зохицуулалтыг харилцан уялдаатай тодорхойлох санал боловсруулав.

Гурав. "Шүүхийн цахимжилтын төв"-ийн эрх зүйн байдал, харьяалал

3.1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяанд "Шүүхийн инновац, цахимжилт, мэдээллийн технологийн төв" (цаашид "Цахимжилтын төв" гэх)-ийг шүүхийн Тамгын газрын бүрэлдэхүүнд зохион байгуулалтын хэлбэрээр ажиллуулах эрх зүйн үндсийг тогтооно. Цахимжилтын төв нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа, түүний бодлого, удирдлага, хяналтын хүрээнд ажиллах бөгөөд бүтэц, орон тоо, ажиллах дүрмийг Шүүхийн ерөнхий зөвлөл батлахаар зохицуулна.

3.2. Үндсэн чиг үүрэг, хамрах хүрээ

Цахимжилтын төвийн чиг үүрэгт бүх шатны шүүх, түүний дотор Улсын дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах нэгдсэн цахим системийн техникийн хөгжүүлэлт, ашиглалт, харилцан ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хамруулахаар тодорхойлно. Энэ нь шүүх бүрийн хэрэг хянан шийдвэрлэх бүрэн эрх, шүүгчийн хараат бус байдал болон Улсын дээд шүүхийн хуульд заасан бүрэн эрхэд харшлахгүй байх зарчимтай нийцнэ. Цахимжилтын төв нь дараах чиг үүрэг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгав. Үүнд:

- Шүүхийн нэгдсэн цахим талбар, программ хангамж хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглах, хэвийн ажиллагааг хангах;
- Мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сервер, сүлжээ, өгөгдлийн дэд бүтэц хөгжүүлэх, ашиглалтыг зохион байгуулах;
- Шүүхийн өгөгдлийн ангилал, чанар, стандарт, хадгалалт, нөөцлөлт, нөхөн сэргээлт, харилцан ажиллагааны мэргэжлийн зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- Кибер аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалтын техник, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюун, блокчэйн болон бусад технологийн шийдлийг хүний хяналт, хуульд нийцсэн хамгаалалтын хүрээнд судлах, турших, нэвтрүүлэх;
- Цахимжилтын бодлого, стандарт, аргачлалын санал боловсруулж Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулах, шүүхийн ажилтнуудын мэргэжлийн чадавх, хэрэглэгчийн дэмжлэгийг хөгжүүлэх.

3.3. Шүүхийн өгөгдлийн дэд бүтэц, дата төв

Шүүхийн үйл ажиллагаанд үүсэх мэдээлэл, өгөгдлийг хуульд нийцүүлэн хадгалах, хамгаалах, нөөцлөх, нөхөн сэргээх, боловсруулах зориулалттай бие даасан өгөгдлийн дэд бүтцийг үе шаттай байгуулах, хөгжүүлэхтэй холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, Цахимжилтын төвийн хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон. Худалдан авах ажиллагааны хүрээнд нэгэнт худалдан авсан хадгалах төхөөрөмжийн бодит ашиглалт, сул багтаамж, өргөтгөх боломжийг үнэлж, дата төвийн цогц шийдлийг төлөвлөх шаардлагыг харгалзав.

Цаашид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжилт эрчимжих хэрээр цагдаа, прокурорын мэдээллийн системтэй хуульд нийцүүлэн харилцан холбогдох боломж бүрдүүлэх, шаардлагатай эрх зүйн болон аюулгүй

байдлын нөхцөл бүрдмэгц эрүүгийн хэргийн цахим өгөгдлийг хадгалах, хамгаалах технологийн чадавхтай байх чиглэл баримтална.

3.4. Удирдлага, хүний нөөц

Цахимжилтын төвийн даргыг томилох, чөлөөлөх, түүний өдөр тутмын удирдлага, ажилтны удирдлага, үйл ажиллагааны тайлагнал, төсвийн эрх хэмжээний зохицуулалтыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяалан шийдвэрлэх асуудалд нийцүүлэн тусгасан. Мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал, өгөгдлийн инженерчлэл зэрэг нарийн мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бүрдүүлэх, ур чадварыг тогтвортой хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Шүүхийн цахим систем хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглахад шүүгчийн мэргэжлийн оролцоо, манлайллыг хангах нь цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлэх чухал нөхцөл тул цахим системийн үйл ажиллагаанд шүүгчийн мэдлэг, туршлагыг ашиглах зорилгоор шүүгчийг тодорхой хугацаагаар Цахимжилтын төвд ажиллуулах боломжийг хуулийн төсөлд тусгасан. Ингэхдээ шүүгчийн өөрийнх нь санал, тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний саналыг үндэслэн, шүүхийн ажлын ачааллыг харгалзан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрээр нэг жил хүртэл хугацаагаар ажиллуулах, цалин хөлсийг нь хэвээр олгох, тухайн хугацааг шүүгчээр ажилласанд тооцох баталгааг хуулийн төсөлд тусгав.

3.5. Төсөв, санхүүжилт

Хуулийн төслөөр Цахимжилтын төвийн үйл ажиллагааг улсын төсвөөс тогтвортой санхүүжүүлэх эрх зүйн үндэс бүрдүүлэх, төвийн төсөв, санхүүжилтийг шүүхийн төсвийн тогтолцоотой уялдуулан зохицуулахыг зорьсон. Ингэснээр шүүхийн цахимжилтын бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалтын хүрээнд бүрдүүлэх нөхцөл бий болно.

Цахимжилтын төвийн урсгал зардал, мэргэжлийн хүний нөөц, цахим системийн хөгжүүлэлт, ашиглалт, засвар үйлчилгээ, технологийн дэд бүтцийн өргөтгөл, мэдээллийн болон кибер аюулгүй байдлын зардлыг шүүхийн төсөвт тусгайлан төлөвлөж, санхүүжүүлэх зохицуулалтыг бүрдүүлэхэд чиглэнэ. Энэ нь шүүхийн цахимжилтын өдөр тутмын үйл ажиллагааны санхүүжилтийг урт хугацааны хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлийн төлөвлөлттэй уялдуулан шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Түүнчлэн Цахимжилтын төвийн төсвийн захирагчийн эрх хэмжээ, төсөв боловсруулах, батлуулах, зарцуулах, тайлагнах харилцааг Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн зохицуулалттай уялдуулахаар тусгасан. Ингэснээр төсвийн удирдлага, хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяанд Цахимжилтын төвийн үйл ажиллагааг санхүүгийн хувьд тогтвортой хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

Дөрөв. Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн үндсэн чиглэл

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шүүхийн захиргааны бүтэц, Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, шүүхийн хүний нөөц, санхүү, эдийн засгийн баталгаа

болон төсвийн эрх хэмжээтэй холбоотой зохицуулалтад дараах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар төсөв боловсруулав. Үүнд:

- 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт Шүүхийн цахимжилтын төвийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяанд ажиллуулах;
- 71 дүгээр зүйлд шүүхийн мэдээлэл, өгөгдөл хадгалах, хамгаалах, боловсруулах зориулалттай бие даасан өгөгдлийн дэд бүтэц (дата төв) байгуулах Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийг тусгах;
- Хуулийн төсөлд шинээр 71^1, 71^2 дугаар зүйл нэмж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяанд ажиллах Шүүхийн цахимжилтын төвийн эрх зүйн байдал, чиг үүрэг, бүтэц, орон тоо, дүрэм болон төвийн даргын бүрэн эрхийг зохицуулах;
- 72 дугаар зүйлийн 72.1.9, 74 дүгээр зүйлийн 74.1.3, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт Шүүхийн цахимжилтын төвийн даргын томилгоо, цахимжилтын баталгаа, төсвийн харьяаллын зохицуулалтыг нийцүүлэх;
- Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.14, 16 дугаар зүйлийн 16.4.11 дэх заалтыг төвийн төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн зохицуулалттай уялдуулах.

Тав. Хуулийн төслийн хүлээгдэж буй үр дүн

- Бүх шатны шүүхийн цахим систем хөгжүүлэх, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцах мэргэжлийн чиг үүрэг, удирдлагын харьяалал тодорхой болно.
- Шүүхийн цахим систем, мэдээлэл, өгөгдлийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах, кибер аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тасралтгүй ажиллагаа, нөөцлөлт, нөхөн сэргээлтийн чадавхыг бэхжүүлэх нөхцөл бүрдэнэ.
- Шүүхийн өөрийн мэргэшсэн баг, технологийн чадавх бүрдүүлэх зохион байгуулалтын суурь бий болно.
- Шүүхийн бие даасан дата төв хөгжүүлэх, бусад байгууллагын системтэй хуульд нийцүүлэн харилцан холбогдох ажиллагааг өргөжүүлэх боломж нэмэгдэнэ.
- Төвийн үйл ажиллагааны санхүүжилтийг урт хугацааны зорилтод нийцүүлэн төлөвлөх, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бэхжүүлэх нөхцөл сайжирна.
- Олон нийт болон хэргийн оролцогчдын цахимаар шүүхэд хандах үйлчилгээний хүртээмж, найдвартай ажиллагааг дээшлүүлэх үндэс бүрдэнэ.

Төсөл 2026.10.19

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ САНАЛ

1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/71 дүгээр зүйлийн 71.1.31 дэх заалт:

“71.1.31.Шүүхийн үйл ажиллагаанд үүссэн мэдээлэл, өгөгдлийг хадгалах, хамгаалах, ангилах, боловсруулах, дүн шинжилгээ хийх зориулалт бүхий өгөгдлийн дэд бүтцийг байгуулах.”

2/71^{1} дүгээр зүйл:

“71^{1} дүгээр зүйл.Шүүхийн инновац, цахимжилт, мэдээллийн технологийн төв

71^{1}.1.Шүүхийн инновац, цахимжилт, мэдээллийн технологийн төв нь шүүхийн цахим хөгжил, мэдээллийн технологи, өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд ажиллана. /цаашид “Цахимжилтын төв” гэх/

71^{1}.2.Цахимжилтын төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

71^{1}.2.1.Шүүхийн нэгдсэн цахим платформ, программ хангамжийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах;

71^{1}.2.2.Шүүхийн мэдээллийн технологийн дэд бүтэц, техник хангамжийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглалтыг зохион байгуулах;

71^{1}.2.3.Өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохион байгуулах, /Дата төв/

71^{1}.2.4.Шүүхийн өгөгдлийг бүрдүүлэх, түүний нэгдсэн бодлого, стандарт, ангилал, ашиглалт, солилцоог тодорхойлох, боловсруулах;

71^{1}.2.5.Шүүхийн үйл ажиллагаанд үүссэн өгөгдөлд дүн шинжилгээ хийх, шүүхийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох, шүүхийн захиргааны бодлого, төлөвлөлт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд хиймэл оюун, блокчэйн зэрэг дэвшилтэт технологийн шийдлийг судлах, боловсруулах;

71[1].2.6.Шүүхийн цахимжилт, мэдээллийн технологийн чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөл, санал, аргачлал боловсруулж Ерөнхий зөвлөлд танилцуулах;

71[1].2.7.Мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

71[1].2.8.Хуульд заасан бусад бүрэн эрх.

71[1].3.Цахимжилтын төвийн бүтэц, орон тоо, ажиллах дүрмийг Ерөнхий зөвлөл батална.

71[1].4.Цахимжилтын төв, зөвлөгөөн болон шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн, шүүхийн ачааллыг харгалзан Ерөнхий зөвлөлийн шийдвэрээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг нэг жил хүртэл хугацаагаар Цахимжилтын төвд ажиллуулж болох бөгөөд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно."

3/71[2] дугаар зүйл:

"71[2] дугаар зүйл.Шүүхийн инновац, цахимжилт, мэдээллийн технологийн төвийн даргын бүрэн эрх

71[2].1.Цахимжилтын төвийг өдөр тутмын удирдлагаар хангах;

71[2].2.Шүүх, шүүхийн захиргааны байгууллагын цахимжилт, мэдээллийн технологийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, нэгдсэн зохицуулалт хийх;

71[2].3.Шүүхийн мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийн хамгаалалтын хэрэгжилтийг хангах, хяналт тавих;

71[2].4.Цахимжилтын төвийн ажилтныг Ерөнхий зөвлөлд танилцуулснаар томилох, чөлөөлөх;

71[2].5.Цахимжилтын төвийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах;

71[2].6.Цахимжилтын төвийн ажлын тайланг Ерөнхий зөвлөлд танилцуулах;

71[2].7.Хуульд заасан бусад бүрэн эрх.

71[2].8.Цахимжилтын төвийн дарга бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана."

4/72 дугаар зүйлийн 72.1.9 дэх заалт:

"72.1.9.Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга /цаашид "Гүйцэтгэх нарийн бичгийн дарга" гэх/, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Тамгын газрын дарга, Цахимжилтын төвийн даргыг томилох, чөлөөлөх;

Тайлбар: Иргэний тусгай мэдлэг, өндөр ур чадварыг ашиглах зорилгоор Цахимжилтын төвийн дарга, ажилтныг онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж болно."

2 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг:

"68.1.Шүүхийн захиргаа нь Ерөнхий зөвлөл, түүний ажлын алба, бүх шатны шүүхийн Тамгын газар, Шүүхийн инновац, цахимжилт, мэдээллийн технологийн төв болон бусад нэгжээс бүрдэнэ."

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... дугаар/дүгээр сарын ...-ны/ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ